



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 16 өдөр

Дугаар A/81

Улаанбаатар хот

Г Т  
Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг  
бууруулах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д заасныг үндэслэн Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах Нэгдсэн Үндэстний Байгууллагын хамтарсан Глобаль хөтөлбөрийг Монгол Улсад 2018-2021 онд хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг нэгдүгээр, нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах салбар дундын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангаж, үр дүng тооцож ажиллахыг салбар дундын зөвлөл/Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн/-д, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, өвчний оношилгоо, эмчилгээний чанар, үр дүng сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв/Ж.Чинбүрэн/-д, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэхэд бэлтгэх, үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв/Д.Нямхүү/-д, умайн хүзүүний хорт хавдартай тэмцэхэд хүн ам, нийгэм, хамт олны идэвх, оролцоог сайжруулах ухуулга нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/-д, умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлөөс сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар/Д.Ганцэцэг/, умайн хүзүүний хорт хавдрын эмчилгээ, оношилгооны чанар, үр дүng сайжруулах арга хэмжээ авахыг Эмнэлгийн тусlamжийн газар/Я.Амаржаргал/-т тус тус даалгасугай.

5. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөөт тусган санхүүжүүлж, үр дүng тооцож ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга нарт даалгасугай.

6. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, өвчний оношилгоо, эмчилгээнд шаардагдах эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, вакцины хангалтыг үе шаттайгаар жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар/Р.Оюунханд/, Эм, үйлдвэрлэл, технологийн газар/Д.Оюунчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2018 оны  
03. сарын 16.-ны өдрийн 11/02 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах Нэгдсэн  
Үндэстний Байгууллагын хамтарсан Глобаль хөтөлбөрийн хүрээнд 2018-2021  
онд Монгол Улсад хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө

Багц арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжих он, сар/ улирал				Байгууллага	
		2018	2019	2020	2021	Хариу цах	Хамtran ажиллах

**Зорилт 1: Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх хянах ажлын зохицуулалт, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр:**

Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх хянах ажлыг зохицуулах, хэрэгжилтийг хангах нэгж байгуулах	1.Холбогдох байгууллага, хөгжлийн хамтрагч ОУБ-ын төлөөлөл бүхий салбар дундын зөвлөл байгуулах (улирал бүр)	1 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	ХСҮТ ХӨСҮТ НЭМҮТ ОУБ, ТББ
	2.Өвчний оношилгоо эмчилгээний менежмент, хөхөнцөр вирусын эсрэг дархлаажилт, ухуулга нөлөөлөл харилцаа холбооны ажлын хэсэг байгуулах (сар бүр)	1 ул	1-4ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	ХСҮТ ХӨСҮТ НЭМҮТ НҮБХС НҮБХАС ОУБ, ТББ
	3.Шаардагдах зардлыг салбарын төсөв, Эрүүл мэндийг дэмжих санд тусгах, бусад эх үүсвэрийг олох, зохицуулах асуудлыг хамtran судлах, хэлэлцэх	6,12 сар	1,6, 12 сар	1,6, 12 сар	1,6, 12 сар	ЭМЯ	ХСҮТ ХӨСҮТ НЭМҮТ
	4.Хүний хөхөнцөр вирусын эсрэг дархлаажилтын талаар танилцуулга бэлтгэн Дархлаажуулалтын зөвлөх хороонд танилцуулах, цаашид хамtran ажиллах	1-2 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	Ажлын хэсэг
	5.Вакцины олон хэв шинж байгаатай холбоотойгоор манай улсад хэрэглэх вакцины хэв шинжийг сонгох талаар судалгааны ажил хийх	1-2 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	Ажлын хэсэг
	6.Хүний хөхөнцөр вирусын эсрэг дархлаажуулалтын санхүүжилтийг төсөвт тусгах	-	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	Ажлын хэсэг ДЗХ

	7.Хүний хөхөнцөр вирусын эсрэг вакциныг дархлаажуулалтын үндэсний товлолд үе шаттайгаар оруулах асуудлыг судлах, бэлтгэх, шийдвэрлэх		1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	Ажлын хэсэг
--	--	--	--------	--------	--------	-----	-------------

**Зорилт 2: Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хянах болон хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины талаарх нийт хүн ам, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч болон зорилтот бүлгийн мэдлэг, ойлголтыг сайжруулах**

Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хянах ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны стратеги боловсруулж , хэрэгжүүлэх	1.Ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны цогц стратеги боловсруулах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дархлаажуулалтын эрсдлийн менежментийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө (3сар x 4 хүн ДЭМБ-ын төлөөлөл) боловсруулах	1-2 ул	-	-	1-4 ул	НЭМҮТ ХСҮТ ХСҮТ	Японы ЗГ-ын төсөл ДЭМБ
	2. Ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны стратегийн хэрэгжүүлэх	2-4 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	НЭМҮТ ХСҮТ ХСҮТ	ЭМЯ, ОУБ, ТББ
	3.Хүний хөхөнцөр вирусын вакцины нэвтрүүлсэн төслийн үр дүнг судлах	2017 - 2018 1 ул	-	-	1,6, 12 сар	МХҮЗ-ТББ	Австралийн ЗГ төсөл
	4.Судалгааны үр дүнг Эрүүл мэндийн яам, шийдвэр гаргагчид танилцуулах	1 ул	1ул	1ул	1 ул	МХҮЗ-ТББ Австр. ЭСЯ	Австралийн ЗГ төсөл
	5.Судалгааны үр дүнг хүн ам, бусад зорилтот бүлэгт мэдээлэх асуудлыг холбогдох ажлын хэсэгтэй тохиролцож, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	2-4 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	МХҮЗ-ТББ Австр. ЭСЯ	Австралийн ЗГ төсөл
	6.Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины дархлаажуулалтын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийн агуулгыг судлан тандах гэж нэмэх	2-4 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	МХҮЗ-ТББ Австр. ЭСЯ	Австралийн ЗГ төсөл
	7. Умайн хүзүүний хорт хавдрын менежмент, хүний хөхөнцөр вирусын эсрэг вакцины талаар төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт оруулах	-	-	1ул	1-4 ул	АШУҮИС	НЭМҮТ ХСҮТ ХСҮТ

	8.Хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтын асуудлыг гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналт, бэлгийн замын халдварт, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, сайн дурын шинжилгээ оношилгоо, үйлчлүүлэгчид чиглэсэн зөвлөгөө, зан үйлийг өөрчлөх харилцаа зэрэг эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай уялдуулах	2-3 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ	ХСҮТ ХӨСҮТ НЭМҮТ Аймаг, нийслэлий н ЭМГ
	9.Зорилтот бүлгийн дунд хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины талаарх мэдлэг, дадлага, хандлагыг үнэлэх форматив судалгаа хийх					МХҮЗ ТББ	Австралий н ЭСЯ
	10. Бодлого боловсруулагчид, эцэг эх, хэвлэл мэдээлэл, сургуулийн ажилтнууд, өсвөр үеийнхэн/зорилтот бүлгүүд, эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зориулсан ухуулга нөлөөллийн багц боловсруулах, хэвлэх	3 ул	1-4ул	1-4 ул	1-4 ул	НЭМҮТ ХӨСҮТ ХСҮТ	Японы ЗГ- н төсөл ДЭМБ Авст. ЗГ
	11.Хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтын үр дүн, нэвтрүүлсэн туршлагын талаар бусад орны тэргүүн туршлагыг судлах, хэвлэл мэдээлэл гаргах	2-4 ул	1-4ул	1-4 ул	1-4 ул	НЭМҮТ ХӨСҮТ МХҮЗ ТББ	ДЭМБ Австралий н ЭСЯ
Бүх шатлалын эмнэлгийн мэргэжилт нүүдийн чадавхийг бэхжүүлэх (вакцин, илрүүлэг, эмчлэх арга, эрт оношилгоон ы талаарх ойлголт )	1. Бүх шатлалд эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдийн тус вакцины талаарх буруу ойлголт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний менежментийн чиглэлээр сургалтын багц хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх	4ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ХСҮТ ХӨСҮТ	ЭМЯ Аймаг, нийслэлий н ЭМГ, ОУБ ТББ
	2.Сургалт зохион байгуулах: - Өрхийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүд (СЭМТ-2073, ӨЭМТ-220) - Аймаг, дүүргийн НЭМТ, БОЭТ (78) - Төрөлжсөн эмнэлэг төв(13)	3-4 ул	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ХСҮТ ХӨСҮТ МӨАУХ	ЭМЯ Аймаг, нийслэлий н ЭМГ, ТББ

	3. Дархлаажуулалтын өмнөх бэлтгэл, явц, дархлаажуулалтын дараах нөхцөл байдалд дэмжлэгт хяналт хийх	-	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ХӨСҮТ	ЭМЯ Ажлын хэсгүүд
	4. Хүний хөхөнцөр вирусын эсрэг дархлаажуулалтын талаар эрүүл мэндийн хичээлийн агуулгад тусгах	-	2-3 ул	1-4 ул	-	НЭМҮТ ХӨСҮТ	БСШУСЯ Орон нутгийн ЭМБ, ТББ
	5. Олон нийт болон сургуульд суурилсан төсөл боловсруулах, хэрэгжүүлэх	-	3 ул	1-4 ул	1-4 ул	НЭМҮТ ТББ/ ИНБ	БСШУСЯ ЭМЯ

**Зорилт 3: Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг Үндэсний дархлаажуулалтын хөтөлбөрт тусгах**

Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэх асуудлыг үндэсний Дархлаажуулалтын зөвлөл хороонд танилцуулах, шийдвэр гаргуулах	1.Хүний хөхөнцөр вирусын эсрэг вакцин нэвтрүүлэх, "GAVI"-ийн үнээр вакцин худалдан авч хангах асуудлаар зөвшилцэх албан захиаг Дархлаажуулалтын зөвлөх хороо/ДЗХ/-д хүргүүлэх, танилцуулах	1 ул	-	-	1-4 ул	ЭМЯ	Ажлын хэсэг ХӨСҮТ НҮБХС
	2.Дархлаажуулалтад шаардагдах төсвийг улсын төсөвт суулгах (Сангийн яаманд захиа хүргүүлэх)	1,3 ул	1 ул	1ул	1-4 ул	ЭМЯ	Ажлын хэсгүүд
	3. НҮБ-ын хамтарсан багийн гишүүд, зөвлөх ДЗХ-той хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх	1-2 ул	1-4 ул	1-4 ул	1,6, 12 сар	ЭМЯ	НҮБХС НҮБХАС ДЭМБ
	4. Монгол улсад умайн хүзүүний хорт хавдрын улмаас эрүүл мэнд, эдийн засагт учирч буй дарамтын судалгаа хийх (зөвлөх 2 хүн х 1.5 сар), танилцуулах	1-2 ул	-	-	1-4 ул	ХСҮТ	ХӨСҮТ Японы ЗГ-ын төсөл, ТББ
	5.Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэх өртөг зардлын тооцоолол хийх (PRIME эсвэл One Health аргачилал), танилцуулах	1-2 ул	-	-	-	ХӨСҮТ	ХСҮТ Японы ЗГ-ын төсөл

	6.Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины үр ашгийг тооцох судалгаа хийх (1 хүн х 1 сар)	1-2 ул	-	-	1-4 ул	ХӨСҮТ Рота вирусын Судалгаа хийсэн баг	ХСҮТ ЭМЯ ДЭМБ
Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэхтэй холбоотой судлагааны дүгнэлт, бусад материал цуглуулах	1.Вакцин үйлдвэрлэгчийн вакцины лицензийн асуудлыг шалгах	2-4 ул	-	-	1-4 ул	ЭМЯ	ХӨСҮТ
	2. 2019-2020 онд нэвтрүүлж эхлэх вакциныг санхүүжүүлэх эх үүсвэр, байгууллагыг тогтоох	1-3 ул	1 ул	-	-	ЭМЯ	ДЭМБ Австралийн ЭСЯ НҮБХАС
	3. Дархлаажуулалтын төсөвт вакцины зардлыг тусгах талаар ЭМЯ-д танилцуулах, шийдвүүлэх (2019 оноос хойшхи)	1 ул	-	-	-	ХӨСҮТ	ХСҮТ

**Зорилт 4: Умайн хүзүүний хорт хавдрын урьдал өвчиний өвчний илрүүлэг, эмчилгээний чанар, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх**

Умайн хүзүүний хорт хавдрын урьдал өвчиний эрт илрүүлэг, эмчилгээ, хамралтыг сайжруулах	1.Холбогдох үндэсний удирдамж, аргачиллыг дахин нягталж, шинэчлэх  2. Умайн хүзүүний хорт хавдрын урьдал өвчиний эрт илрүүлэг, эмчилгээнд эмэгтэйчүүдийн эмч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалтыг бүсчилэн зохион байгуулах	2-3 ул	-	-	1-4 ул	ЭМЯ	ХСҮТ ЭСҮТ ХӨСҮТ ЭМБ-Д ТББ
Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх асуудлыг хариуцсан байгууллагын чадавхийг бэхжүүлэх	1.Цитолог, паталог, колъпоскопи, эпидемиологи, хяналтын чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах	4 ул	1-4 ул	1ул	1-4 ул	ХСҮТ	МКУХЭСН ЭСҮТ ЭМХТ
	2. Аймаг, дүүргийн түвшинд хавдрын эрт илрүүлэг хариуцсан мэргэжилтэнтэй болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлэх	-	1-4 ул	1-4 ул	1-4 ул	ЭМЯ ХСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
	3. Өрхийн эмч, сувилагч, эмэгтэйчүүдийн эмч,	4 ул	1-4 ул	-	1-4 ул	ХСҮТ ЭСҮТ	ЭМХТ Аймаг,

	цитологийн эмч, эмгэг судлаач эмч, хавдрын эмэгтэйчүүдийн эмч, хавдар бүртгэгч зэрэг мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх							нийслэлийн ЭМГ
--	--	--	--	--	--	--	--	----------------

**Зорилт 5: Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгоо, менежментийн чадамжийг бэхжүүлэх**

Лабораторийн чадавхийг бэхжүүлэх	1.Эсийн шинжилгээ хийдэг лабораторийн ажилтанд сургалт зохион байгуулах	4 ул	1 ул	-	1-4 ул	ЭСҮТ	МКУХЭСН ЭМХТ
	2.Лабораторийн үр дүнг мэдээлэх асуудлыг сайжруулах	-	1 ул	1-4 ул	1-4 ул	ЭСҮТ	ХСҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ
Умайн хүзүүний хорт хавдартай өвчтөнд багаар үйлчлэх чадавхийг бэхжүүлэх	1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зургалал, вакциныг яаж хүлээж авч байна, ямар мэдлэгтэй байгаа талаарх форматив судалгаа хийх (1.5сар х 2 хүн)	4 ул	1-4 ул	-	1-4 ул	ХӨСҮТ Австралийн ЭСЯ ТББ	ХӨСҮТ Австралийн ЭСЯ ТББ
	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа шалтгааныг тогтоох судалгаа хийх	2-4 ул	Жил бүр	Жил бүр	Жил бүр	ХӨСҮТ Австралийн ЭСЯ ТББ	ХӨСҮТ Австралийн ЭСЯ ТББ
	2.Орон нутагт хорт хавдрын эсрэг эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах	-	-	1ул		ХСҮТ, Орон нутгийн ЭМБ	ЭМХТ ХӨСҮТ ТББ
	3.Өвчний оношилгоо, эмчилгээ, өвчтөнд дэмжлэг үзүүлэх, хянах удирдамжийг боловсронгуй болгох	2-3 ул	1-2	-	1-4 ул	ХСҮТ ТББ	ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ
	4.Хими эмчилгээг удирдах асуудлаар хавдрын сувилагчдыг сургалтад хамруулах	4 ул	1-2 ул	-	1-4 Ул	ХСҮТ	ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ
Олон нийтэд тулгуурласан хөнгөвчлөх эмчилгээг	1.Хөнгөвчлөх эмчилгээний удирдамжийг хянах, шинэчлэх		2 ул	-	1-4 ул	ХСҮТ	ДЭМБ ЭМЯ
	2.Хөнгөвчлөх эмчилгээний асуудлаар олон нийтийн идэвхтний чадавхийг сайжруулах (ӨЭМТ/СЭМТ)	-	-	2ул	1-4 Ул	ХСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, ТББ

дэмжих	3.Хөнгөвчилөх эмчилгээнд олон нийтийн гишүүдийг оролцуулах	-	1ул	1-4 ул	1-4 ул	ХСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, МӨАУХ
Туяа эмчилгээг чадавхийг сайжруулах	1.3D IGBT технологи бүхий брахиатерапи эмчилгээний нэгж байгуулах	-	-	TBC	1-4 ул	ХСҮТ	ЭМЯ ОУЦЭА
	2.Брахия эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх, ОУЦЭА-ын зөвлөхтэй хамтран үндэсний семинаар зохион байгуулах	-	-	TBC	1-4 ул	ХСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ ОУЦЭА
	3.Туяа төлөвлөгөөг эмчилгээний боловсронгуй болгох	-	3ул	-	1-4 ул	ХСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ ОУЦЭА

**Зорилт 6: Умайн хүзүүний хорт хавдартай тэмцэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ болон тандалтын тогтолцоо бий болгох**

Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хянах, ялангуяа хүн амд сууринсан тандалт, бүртгэлийг сайжруулах	1.Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, бүртгэл, хяналтын шалгуур үзүүлэлтийн стандарт боловсруулж, хэрэгжүүлэх	3 ул	1 ул	1-4 ул	1-4 ул	ХСҮТ ЭСҮТ	СХҮТ ЭМХТ
	2. Хавдрын эмчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулах (жишээ нь, туяа эмчилгээ хийх хугацаа, туяа эмчилгээнд бүрэн орсон өвчтөний эзлэх хувь)	-	2-3ул	-	1-4 ул	ХСҮТ	ЭМЯ Аймаг, нийслэлийн ЭМГ
	3.Өвчтөнд шинжилгээний дүн хүргэхэд технологийн шийдлийг ашиглах (SMS мэссаж гэх мэт ) нөхцөл бүрдүүлэх, хэрэгжүүлэх	-	3ул	1-4 ул	1-4 ул	ХСҮТ	НЭМҮТ
	4.Одоогийн эрт илрүүлгийн бүртгэлийн системийг сайжруулж, хамралтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	-	2-3 ул	1-4 ул	1-4 ул	ХСҮТ ЭМЯ ҮСГ	ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ
	5.Эргэн дуудах системийн бүртгэлийн менежментийг сайжруулах сургалт зохион байгуулах	2-3 ул	-	-	1-4 ул	ХСҮТ	ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ
	6.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ боловсруулах	2-3 ул	2 ул	-	1-4 ул	ХСҮТ	ХӨСҮТ ЭМЯ

Умайн хүзүүний хорт хадвраас сэргийлэх, хянах оператив судалгааг сайжруулах	1.Бүсийн хэмжээнд хүний хөхөнцөр вирусийг илрүүлэх оношлуур турших туршилтын төслийг хэрэгжүүлэх (цитологийн шинжилгээтэй триад)	-	3-4ул	-	1-4 ул	ХСҮТ ЭСҮТ МКУХЭ СН	ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ
	2. Умайн хүзүүний хавдрын эмчилгээний гаж нөлөөний талаар клиникийн судалгаа хийх, чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах	-	3 ул	-	1-4 ул	ХСҮТ ЭСҮТ МКУХЭ СН	ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ

-оOo-

Эрүүл мэндийн сайдын 2018 оны  
03.сарын 16.ны өдрийн A/82...дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

Монгол Улсад Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах  
Нэгдсэн Үндэстний Байгууллагын хамтарсан Глобаль хөтөлбөрийг 2018-2021 онд  
хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг  
хангуулах салбар дундын зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга:


Нарийн бичиг:

Гишүүд

- Эрүүл мэндийн дэд сайд;
- Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга;
- Эмнэлгийн тусlamжийн газрын дарга;
- Эм, үйлдвэрлэл технологийн газрын дарга;
- Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын Суурь бүрэн дунд боловсролын стандарт хөтөлбөр, аргазүйн бодлого хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн;
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн;
- Хавдар судлалын үндэсний төвийн дарга;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дарга;
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга;
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгч;
- НҮБ-ын Хүүхдийн сангийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;
- НҮБ-ын Хүн амын сангийн Шадар суурин төлөөлөгч;
- Монгол улс дахь Австрали Улсын Элчин сайд/зөвшилцсөнөөр/;
- Монголын хавдрын үндэсний зөвлөл"-төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал;
- Монголын коль поскопи, умайн хүзүүний хорт хавдрын эмгэг судлалын нийгэмлэгийн тэргүүн.

-оОо-

Эрүүл мэндийн сайдын 2018 оны  
03.сарын 16.-ны өдрийн 482..дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт



Монгол Улсад Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас барагтыг бууруулах  
Нэгдсэн Үндэстний Байгууллагын хамтарсан Глобаль хөтөлбөрийг 2018-2021  
онд хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах  
ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам

**1. Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх хүний хөхөнцөр вирусийн  
эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах,  
нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:**

Ажлын хэсгийн дарга:

-Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын Тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн дарга;

Нарийн бичгийн дарга:

-Халдварт өвчин судлалын үндэсний төв/ХӨСҮТ/-ийн Тандалт эрхэлсэн дэд захирал;

Гишүүд:

-ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газар/НЭМГ/-ын дарга;

-ЭМЯ-ны Эдийн засаг, санхүүгийн хэлтэс/ЭЗСХ/-ийн дарга;

-ЭМЯ-ны ЭЗСХ-ийн Улсын төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

-ЭМЯ-ны Тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн Дархлаажилт бүхий халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн;

-ЭМЯ-ны Эмнэлгийн тусlamжийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн;

-ЭМЯ-ны НЭМГ-ын Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн;

-Хавдар судлалын үндэсний төвийн Бодлого, төлөвлөлт, хөгжил эрхэлсэн дэд захирал;

-Халдварт өвчин судлалын үндэсний төв/ХӨСҮТ/-ийн Дархлаажуулалтын албаны дарга;

-ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны шинэ вакцины тандалт хариуцсан мэргэжилтэн;

-НЭМҮТ-ийн Биотехнологи, инновацийн албаны дарга;

-ХСҮТ-ийн Бүртгэл тандалт, эрт илрүүлгийн албаны дарга;

-ХСҮТ-ийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч;

-Нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга;

-Нийслэлийн Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн вакцинатор;

- ДЭМБ-ын Дархлаажуулалтын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;
- ДЭМБ-ын Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;
- ДЭМБ-ын Эх, хүүхдийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн;
- НҮБ-ын Хүн амын сангийн Зайн оношилгооны эх, нярайн асуудал хариуцсан мэргэжилтэн
- НҮБ-ын Хүүхдийн сангийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;
- “Монголын Хавдрын үндэсний зөвлөл” Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал/тохиролцсоноор/.

#### 1.1. Ажлын хэсгийн ажиллах удирдамж:

1.1.1. Тус ажлын хэсэг үндэсний дархлаажуулалтад шинэ вакцин нэвтрүүлэх удирдамжийн дагуу хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэхэд бэлтгэх, нэвтрүүлэх ажлыг хариуцна.

1.1.2. Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх үндэслэл, тооцоог Дархлаажуулалтын зөвлөх хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган 5 дугаар сарын 1-ний дотор танилцуулах;

1.1.3. Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг 2019-2020 оноос эхлэн дархлаажуулалтад нэвтрүүлэх үйл ажиллагаа, шаардагдах санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөө (2019-2022 он)-г боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

1.1.4. Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины товлол, хэрэглэх заавар, вакцины дараа гарч болзошгүй урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх заавар, судалгаа, тандалтын зааврыг ДЭМБ-ын удирдамжид үндэслэн 2018 онд багтаан боловсруулах, батлуулах;

1.1.5. Дархлаажуулалтад шаардагдах хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцин, дагалдах хэрэгслийн төсвийн тооцоог жил бүр төсвийн төлөвлөлтийн шаардагдах хугацаанд гарган яамны Эдийн засаг, санхүүгийн хэлтэст хүргүүлж байх;

1.1.6. Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэхтэй холбоотой мэдээ, бүртгэлийн хуудас маягтуудыг 2018 онд багтаан боловсруулж, ашиглахад бэлтгэх;

1.1.7. Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцин, өөрөө эвдэрдэг тариур, аюулгүй хайрцаг, хөргөгчийн захиалтыг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлж хамтран ажиллахад бэлтгэх;

1.1.8. Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг дархлаажуулалтанд үе шаттайгаар нэвтрүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, вакцин нэвтрүүлэх үндэслэл, шаардлагатай холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг цаг тухайд нь авч, мэдээллийг цаг тухайд гаргаж өгч байх;

1.1.9.Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэхэд шаардлагатай үндэсний болон олон улсын нотолгоог бэлтгэж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид түгээх, хэрэгжилтэд хамрагдах зорилтот бүлэгт түгээх, мэдлэг, хандлагыг өөрчлөх ажлыг ХСҮТ, НЭМҮТ-тэй хамtran зохион байгуулах;

1.1.10. Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас бааралтыг бууруулах НҮБ-ын хамтарсан Глобаль хөтөлбөр хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах салбар дундын зөвлөлд ажлаа танилцуулж, хамtran ажиллах.

**2. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чанар, үр дүнг сайжруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:**

- |                       |   |
|-----------------------|---|
| Ажлын хэсгийн дарга:  | -Хавдар судлалын үндэсний төв/ХСҮТ/-ийн дарга;  |
| Нарийн бичгийн дарга: | -ХСҮТ-ийн сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал;   |
| Гишүүд:               | -ЭМЯ-ны НЭМГ-ын ХБӨ-ний асуудал хариуцсан мэргэжилтэн;<br>-ЭМЯ-ны ЭТГ-ын Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн;<br>-Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга;<br>-Эмгэг судлалын үндэсний төвийн дарга;<br>-ХСҮТ-ийн Бодлого, төлөвлөлт, хөгжил эрхэлсэн дэд захирал;<br>-Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмэгтэйчүүдийн эмнэлгийн захирал;<br>-ХСҮТ -ийн Бүртгэл тандалт, эрт илрүүлгийн албаны дарга;<br>-ХСҮТ-ийн Нийгмийн эрүүл мэнд, сургалт, мэдээллийн албаны дарга;<br>-ХСҮТ-ийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч;<br>-ХСҮТ-ийн Туяа эмчилгээний тасгийн эрхлэгч;<br>-ХСҮТ-ийн Хөнгөвчлөх эмчилгээний тасгийн эрхлэгч;<br>-ДЭМБ-ын Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;<br>-ДЭМБ-ын Дархлаажуулалтын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;<br>-ДЭМБ-ын Эх, хүүхдийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн;<br>-НҮБ-ын Хүүхдийн сангийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;<br>-НҮБ-ын Хүн амын сангийн Зайн оношилгооны төслийн менежер;<br>- Эх барих, эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн гишүүн;<br>-“Монголын хавдрын үндэсний зөвлөл” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал. |

## 2.1. Ажлын хэсгийн ажиллах удирдамж:

2.1.1. Тус ажлын хэсэг нь умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чанар, үр дүнг үндэсний хэмжээнд сайжруулах үндсэн үүрэгтэйгээр ажиллана.

2.1.2. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа шалтгааныг тогтоож, арилгах, үр дүнг сайжруулах төлөвлөгөө, шаардагдах санхүүжилтийн тооцоог гарган батлуулж, хэрэгжүүлэх;

2.1.3. ДЭМБ-ын баталсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний удирдамжид үндэслэн үндэсний хэмжээнд мөрдөгдэж байгаа умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, бүртгэл мэдээллийн удирдамжийг боловсронгуй болгох;

2.1.4. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээний чанар, үр дүнг сайжруулахаад оролцогч байгууллагуудын чадамж, оролцоог сайжруулах, холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг цаг тухайд нь авч, мэдээллийг цаг тухайд гаргаж өгч байх;

2.1.5. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

2.1.6. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээтэй холбогдох мэдээлэл, сургалт, сурталчилгааг НЭМҮТ, ХӨСҮТ-тэй хамtran зохион байгуулах;

2.1.7. Умайн хүзүүний хорт хавдраар өвчилж, эмчилгээ нь үр дүнтэй болсон өвчтөнийг өөрсдийн хүсэлтээр умайн хүзүүний хорт хавдартай тэмцэх арга хэмжээнд оролцуулах, эрүүл аж төрөх, хорт хавдраас сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг өвчтөнд тогтмол өгдөг болгох;

2.1.8. Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас бааралтыг бууруулах НҮБ-ын хамтарсан хамтарсан Глобаль хөтөлбөр хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах салбар дундын зөвлөлд ажлаа танилцуулж, хамtran ажиллах.

## 3. Умайн хүзүүний хорт хавдартай тэмцэхэд хүн ам, нийгэм, хамт олны оролцоо, идэвхийг сайжруулах ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга:

- НЭМҮТ-ийн дарга;

Нарийн бичгийн дарга:

- НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих, өвчинөөс

урьдчилан сэргийлэх албаны дарга;

Гишүүд:

- ЭМЯ-ны Тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн

дарга;

- ЭМЯ-ны хэвлэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

- Хавдар судлалын үндэсний төвийн дэд захирал;

- ЭТГ-ын Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын Суралцагчийн хөгжил төлөвшил, хамгааллын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн;
- ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны шинэ вакцины тандалт хариуцсан мэргэжилтэн;
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмэгтэйчүүдийн эмнэлгийн захирал;
- ДЭМБ-ын Дархлаажуулалтын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;
- ДЭМБ-ын Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;
- ДЭМБ-ын Эх, хүүхдийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн;
- НҮБ-ын Хүүхдийн сангийн өсвөр үеийн оролцоо, ХДХВ,ДОХхариуцсан мэргэжилтэн/тохиролцсоноор/
- НҮБ-ын Хүүхдийн сангийн хөгжлийн мэдээлэл хариуцсан ажилтан /тохиролцсоноор/;
- “Монголын хавдрын үндэсний зөвлөл” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал;
- Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал.

### 3.1. Ажлын хэсгийн ажиллах удирдамж:

3.1.1. Ажлын хэсэг нь хүн ам, зорилтот бүлэг, шийдвэр гаргагчид, хэвлэл мэдээллийнхэн болон холбогдох төрийн бус байгууллагад умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх арга зам, хүний хөхөнцөр вирусийн вакцины ач холбогдлын талаар зөв мэдээлэл өгөх ухуулга, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэйгээр ажиллах;

3.1.2. Дээрх бүлгүүдийн онцлогт тохирсон ухуулга нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах;

3.1.3. Ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны ажлын санхүүжилтийн хүсвэрийг зохицуулах, үр ашигтай зарцуулах;

3.1.4. Умайн хүзүүний хорт хавдрын хор уршиг, түүнээс сэргийлэх арга зам, хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины дархлаажуулалтын ач холбогдлын талаарх хүн амын болон мэдээлэл хүргэгдсэн бүлгийнхний мэдлэг, хандлагын төлөвшилт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийн агуулгыг судлан тандах;

3.1.5. Умайн хүзүүний хорт хавдрын хор уршиг, түүнээс сэргийлэх, хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцины дархлаажуулалтын талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

3.1.6. Ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны ажлыг ХӨСҮТ, ХСҮТ, орон нутгийн эрүүл мэндийн болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.1.7. Холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг цаг тухайд нь авч, гаргаж өгч байх;

3.1.8. Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас барагтыг бууруулах НҮБ-ын хамтарсан хамтарсан Глобаль хөтөлбөр хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах салбар дундын зөвлөлд ажлаа танилцуулж, хамтран ажиллах.

-оОо-